



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-4
<hr/>	
<i>1.Горимын санал</i>	3-4

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий/-ны 03 дугаар сарын 25-ны өдөр /Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 31 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Анужин, Д.Батлут, С.Одонтуяа;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг.

Түр хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ Хянан шалгах түр хорооны дотоод асуудал ярих учраас хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Нээлттэй хуралдаан 04 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 31 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор байгуулагдсан Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул түр хорооны 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Түр хорооны ирцийг танилцуулъя. Ирц Ж.Бат-Эрдэнэ миний бие ирсэн. Тэмүүлэн гишүүн ирсэн, Ж.Чинбүрэн гишүүн ирсэн, Ж.Батсуурь гишүүн ирсэн, Т.Доржханд гишүүн ирсэн, Н.Ганибал гишүүн ирсэн байна аа.

Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Хянан шалгах түр хорооны хянан шалгагч, шинжээч нарыг томилж, ажлын даалгаврыг батлах асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Түр хорооны хянан шалгагч, шинжээч нарыг томилох тухай тогтоолыг хэлэлцэнэ. Түр хорооны хянан шалгагч шинжээч томилох нь Түр хорооны дотоод асуудал бөгөөд Хянан шалгах түр хорооноос томилогдсон, томилогдон ажиллах, хянан шалгагч, шинжээч нарт хөндлөнгөөс нөлөөлөх магадлалтай учраас хуралдааныг хаалттай хийх саналыг оруулж байна аа.

Иймд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийн тус хэсгийг тус тус үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналаар санал хураалт явуулъя аа.

Хуулийнхаа дагуу ер нь хянан шалгагч нарын бид нар чинь бүх анкет бүх зүйлүүдийг ярина шүү дээ. Хаанаасаа сонгож байгаа, хаанаас ямар байгууллагыг төлөөлж байгаа гэдэг тэгээд энийгээ хаалттай явуулъя гэж байгаа юм.

Хаалттай явуулъя гэсэн горимын саналаар санал хураалт явуулах уу?

Хүнтэй холбоотой асуудал гэдгээр нь тийм тийм хаалтаа явуулъя гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

6 гишүүнээс 4 гишүүн зөвшөөрч 86.7 хувиар санал дэмжигдлээ.

*Ингээд хуралдааныг хаалттай
явуулья аа.*

Хаалттай горимд шилжүүлье.

14.35 цагт

Бичлэгээс буулгасан:

ХУРАЛДААНЫ	ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ	АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ	П.МЯДАГМАА